

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234703

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ДАХЬ НЭРИЙН ОРХИЛТ

Г.Баттогтох

Түлхүүр үг: холбоосжилт, нэрийн орхилт, үйлийн орхилт, өгүүлбэрийн орхилт

1. Удиртгал. Холбоосжилт бол юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөний тухай төгс санааг бүрэлдүүлэх гол хэрэглүүр юм. М.А.К.Халлидэй (M.A.K.Halliday), Рукайяа Хасан (Ruqaiya Hasan) нар эхийн холбоосжилт (cohesion)¹-ын тогтолцоог судалж, “Англи хэл дэх холбоосжилт” (Cohesion in English) хэмээх номыг бичиж хэвлүүлсэн бөгөөд уг бүтээлдээ төлөөлүүлэл (Reference), орлуулал (Substitution), орхилт (Ellipsis)², холбоос (Conjunction), үгийн сангийн холбомж (Lexical cohesion) зэрэг ойлголт ухагдахууныг тодорхойлсон байна (1976). Хэл шинжлэлч нар Тогтолцоот үүргийн хэл зүй (Systemic Functional Grammar-SFG) онолын хүрээнд боловсруулсан, дурдсан тогтолцооны дагуу аливаа хэлний холбоосжилтыг судалж, судалгааны бүтээл хэвлүүлж байна. Тэрхүү жишгээр монгол хэлний холбоосжилтыг судлан шинжилж, эхийн хэлбэр төрөлд илрэх утгыг нь тайлбарлах шаардлагатай юм.

Холбоосжилтын зарим төрөл (төлөөлүүлэл, орлуулал, орхилт) хоорондоо төстэй, хамааралтай байдаг тул жишээгээр үзүүлэн, харьцуулъя.

Төлөөлүүлэл:

Би ахын морийг сонирхож байна. Би өмнө нь үүнийг унаж байсангүй.

-үүнийг = ахын морь

Орлуулал:

Би ахын морийг сонирхож байна. Би өмнө нь ийм морь нэгийг ч унаж байсангүй.

-нэг = морь

Орхилт:

Би ахын морийг сонирхож байна. Би өмнө нь үүнээс сайхныг Ө хараагүй.

-сайхан = морь

Энэхүү өгүүлэлд монгол хэлний холбоосжилтоос Монголын нууц товчоон (МНТ) дахь орхилтыг сонгон авч, зүй тогтлыг нь тайлбарлахыг зорив. Түүхэн

¹ Cohesion гэдэг ойлголтыг төгс санааг холбох арга, түүний зүй тогтлын ерөнхий нэршил учир холбоосжилт гэж нэрлэв.

² Ellipsis гэдэг ойлголтыг гээх буюу хагасармал (Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа, 2014: 82) гэж нэрлэх санал гарч байсан болно.

сурвалжийн хэл, түүний мэдээллийн бүтэц, холбоосжилтын онцлогийг судлан шинжлэх нь үндэстний хэл, сэтгэлгээний хэв маяг, өвөрмөц шинжийг тайлан тайлбарлах нэгэн арга болно. Ш.Чоймаа “МНТ-ы хэлийг олон талаас нь, үг хэллэг зарим өгүүлбэр, эхийн зарим хэсэг, зарим үгийн үгийн сангийн утга, үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл зэргийг улам бүр тогтолцоотой судлах зэргээр хэлний олон түвшинд нь судлах ажил эрчимтэй болж байхын хамт харь хэлээр орчуулах, эрдэм шинжилгээний латин галиг хийх, анхны монгол бичгийн эхийг тухайн үеийн үсгийн тиг, зөв бичих ёс, хэл зүйн онцлогоор нь сэргээх, орчин цагийн монгол хэлэнд дахин хөрвүүлж, эртний үг хэллэгийн тайлбар хийх, хожмын монгол түүхэн сурвалжуудтай эх бичиг судлалын үүднээс харьцуулах гэх мэт судалгаа үргэлжлэн хийгдэж, судалгааны чанарын түвшин ч сайжиржээ” (2017б:7) гэж өгүүлсэн байдаг нь сурвалжийн хэлийг судлахын ач холбогдлыг тайлбарласан хэрэг юм.

Орхилт бол эхийн холбоо хамаарлын хэсэг бөгөөд эхэд нэг үг, өгүүлбэрийг дахин давтахгүйн тулд хэрэглэдэг. М.А.К.Халлидэй нар “Орлуулал ба орхилт нь өөр хоорондоо тун төстэй ойлголт юм. Орхилт бол тэгээр орлуулах арга тул уг хоёр ойлголтыг тус тусад нь авч үзэх аргагүй. Гэсэн хэдий ч орлуулал, орхилт нь эхийн суурь бүрдүүлэгч (утгын хувьд үг, өгүүлбэрийн хамаарлыг илтгэхдээ төлөөлүүлээс өөр) болох бөгөөд хоёр өөр төрлийн бүтцийн тогтолцоо, хэв маягийг харуулна. Орхилтын тухай өгүүлэхэд “хэлээгүй үлдээсэн зүйл”-тэй холбоотой ойлголт болно. “Орхисон зүйл юу байна вэ” гэдэг нь ойлгомжгүй хэрэг биш, харин ч тодорхой зүйл байдаг (1976:142), Өгүүлбэрийн орхилт нь нөхцөл байдалтай холбоотой ойлголт юм. Ялангуяа, харилцаа ярианд *тийм, үгүй* гэсэн асуулт-хариулт, асуух төлөөний үг бүхий үгээр орхилт илэрнэ. *Тийм, үгүй* гэдэг үг бүтэн өгүүлбэрийн орхилт болж, хариултын үүрэг гүйцэтгэнэ (2004:563) гэж үзжээ. Тэд энэхүү саналаа *Үүргийн хэл зүйн удиртгал* бүтээлдээ лавшруулж өгүүлсэн байна (2014:635). Түүнчлэн Ж.Томсон “Орхилтыг бичвэрээс илүү харилцаа ярианд голлон хэрэглэдэг. Энэ нь хоёр талын харилцааны тодорхой хэлбэр болох хэлэлцээр өрнүүлэх, хамтын ажиллагааг тогтооход тусалдаг” (2014:220) гэжээ. Эхэлж өгүүлсэн төгс санаа (өгүүлбэр), түүний бүрэлдүүлбэр (нэр үг, үйл үг)-ийг удаах өгүүлбэрт дахин өгүүлэхгүйгээр орхиж, тэг хэлбэр (Ø) -ээр илэрхийлэх байдлаар зохиомжилно. Орхилт нь тэг хэлбэрээр илэрч байгаа тул эхийн утга санааг алдуулахгүй бөгөөд зарим талаар уг зүйлд хандаж буй баймж, үнэлэмжийг илтгэнэ.

Орхилтыг хэлбэрээр нь гурван дэд хэсэгт хувааж үздэг. Үүнд:

1. Нэрийн орхилт. Жишээ нь:

Гурван хүүхэд хот явсан, бас нөгөө гурав нь хөдөө явсан.

Гурван хүүхэд хот явсан, бас нөгөө гурав Ø нь хөдөө явсан.

Гурван хүүхэд хот явсан, бас нөгөө гурав хүүхэд нь хөдөө явсан.

2. Үйлийн орхилт. Жишээ нь:

Та ууланд алхдаг уу? Тийм.

Та ууланд алхдаг уу? Тийм, Ø.

Та ууланд алхдаг уу? Тийм, алхдаг.

3. Өгүүлбэрийн орхилт. Жишээ нь:

Эгч юу тарьж байсан бэ? –Мод.

Эгч юу тарьж байсан бэ? –Мод Ø.

Эгч юу тарьж байсан бэ? –Эгч мод тарьж байсан.

2. Нэрийн орхилт. Юм үзэгдлийн тухай өгүүлсэн төгс санаа (өгүүлбэр)-г нарийвчлах (elobrating), өргөжүүлэх (extending), үргэлжлүүлэх (enhancing) байдлаар тэлдэг. Орхилт бол эхийн бүтцийг хурааж буй хэлбэр мэт боловч угтаа эхийн санааг тэлэх нэгэн арга юм. Монголын нууц товчоонд эхний өгүүлсэн санааг удаах өгүүлбэрт тэг хэлбэрээр илрүүлэн орхих тохиолдол хэд хэд ажиглагдав. Жишээ нь:

§19: “qabur niken üdür köngsilemel qonin cinaju belgünütei бүгүнүtei buqu-qatagi buqatu-salji bodoncar-mungqaq ede tabun kö’üd-iyen jergelen sa’ülju niji’el müsüt ququlutqun ke’ejü ökba niji’el-i ya’u bayi’ulqun ququciju o’orba” (Rachewiltz 1972: 15-16) [Хавар нэгэн өдөр хөншилмөл хонин чанаж, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Буху Хатаги, Бухату Салжи Бодончар мунхаг эд таван хөвүүдээн зэрэглэн суулгаж, нижээл мөсөд “Хугалахун (хугалагтун)” хэмээж өгөв. Нижээлийг юу байгуулахуун, хугачиж ооров. Чоймаа, 2022: 12]. Энэхүү эхийн эхийн төгс нэгжид буй *мөсөд* гэдэг нэрийг удаах төгс нэгжид нь тэг хэлбэрт шилжүүлэн, тойм тоогоор төлөөлүүлэн өгүүлжээ. Уншигч орхисон нэрийг эхийн хам бүтцээс сэргээн ойлгох бөгөөд үүнд ямар нэгэн үл ухагдах байдал гарахгүй. Нэрийн орхилт, түүний тэг хэлбэр болон нөхөн харуулсан жишээг дараах байдлаар загварчилж болно. Үүнд:

1. §19: “qabur niken üdür köngsilemel qonin cinaju belgünütei бүгүнүtei buqu-qatagi buqatu-salji bodoncar-mungqaq ede tabun kö’üd-iyen jergelen sa’ülju niji’el müsüt ququlutqun ke’ejü ökba niji’el Ø ya’u bayi’ulqun ququciju o’orba” (Rachewiltz 1972: 58) [Хавар нэгэн өдөр хөншилмөл хонин чанаж, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Буху Хатаги, Бухату Салжи Бодончар мунхаг эд таван хөвүүдээн зэрэглэн суулгаж, нижээл мөсөд “Хугалахун (хугалагтун)” хэмээж өгөв. Нижээлийг Ø юу байгуулахуун, хугачиж ооров. Чоймаа, 2022:12].

2. §19: “qabur niken üdür köngsilemel qonin cinaju belgünütei бүгүнүtei buqu-qatagi buqatu-salji bodoncar-mungqaq ede tabun kö’üd-iyen jergelen sa’ülju niji’el müsüt ququlutqun ke’ejü ökba niji’el [müsüt-i] ya’u bayi’ulqun ququciju o’orba” (Rachewiltz 1972: 58) [Хавар нэгэн өдөр хөншилмөл хонин чанаж, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Буху Хатаги, Бухату Салжи Бодончар мунхаг эд таван хөвүүдээн зэрэглэн суулгаж, нижээл мөсөд “Хугалахун (хугалагтун)” хэмээж өгөв. Нижээл мөсдийг юу байгуулахуун, хугачиж ооров. Чоймаа, 2022:12].

Монголын нууц товчоонд эрхин үйлдэгчийг тэг хэлбэрээр илрүүлэхээс гадна өртөн үйлдэгчийг тэг хэлбэрээр илрүүлэх жишээ хэд хэд ажиглагдав. Ийнхүү эхийн өртөн үйлдэгчийг орхин өгүүлэхэд эхийн санаа өөрчлөгдөхгүй. Харин цогц санааг хэсэгчлэн хувааж үзвэл утга санаа нь үл ойлгогдох шинжтэй болно. Жишээ нь:

§76: “niken üdür temüjin qasar bekter belgütei dörben qamtu sa’uju geügi tataqui[-tur] dоторa niken gege’en soqosun oroju’ui temüjin qasar qoyar-aca bekter belgütei

qoyar buliju abuba” (Rachewiltz 1972: 29) [Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвөн хамт сууж, гөхий татахуйд, дотор нэгэн гэгээн сугусун оржухуй. Тэмүжин Хасар хоёроос Бэгтэр Бэлгүдэй хоёр булиж авав. Чоймаа, 2022: 36]. Тус эхэд буй “Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвөн хамт сууж, гөхий татахуйд, дотор нэгэн гэгээн сугусун оржухуй” гэдэг эхний төгс санаа нь удаах төгс санаатай нийлж нэгэн цогц санааг бүтээнэ. Тодруулбал, эхний төгс санааг удаах төгс санаа өргөжүүлнэ. Хоёр төгс санааны нийлэмж буюу цогц санааны түвшинд орхилт илэрдэг. Дээрх төгс санааны нэрийн орхилт, түүний тэг хэлбэр болон нөхөн харуулсан жишээг дараах байдлаар загварчилж болно. Үүнд:

1. §76: “niken üdür temüjin qasar bekter belgütei dörben qamtu sa’uju geügi tataqui[-tur] dоторa niken gege’en soqosun oroju’ui temüjin qasar qoyar-aca bekter belgütei qoyar Ø buliju abuba” (Rachewiltz 1972: 58) [Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвөн хамт сууж, гөхий татахуйд, дотор нэгэн гэгээн сугусун оржухуй. Тэмүжин Хасар хоёроос Бэгтэр Бэлгүдэй хоёр Ø булиж авав. Чоймаа, 2022: 36].

2. §76: “niken üdür temüjin qasar bekter belgütei dörben qamtu sa’uju geügi tataqui[-tur] dоторa niken gege’en soqosun oroju’ui temüjin qasar qoyar-aca bekter belgütei qoyar [soqosun-i] buliju abuba” (Rachewiltz 1972: 58) [Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвөн хамт сууж, гөхий татахуйд, дотор нэгэн гэгээн сугусун оржухуй. Тэмүжин Хасар хоёроос Бэгтэр Бэлгүдэй хоёр сугусуныг булиж авав. Чоймаа, 2022: 36].

Ш.Лувсанвандан хэлний бүтцийн тухай өгүүлсэн хэд хэдэн бүтээлдээ “юм үзэгдэл, түүний харьцаа хөдөлгөөн хоёр нь нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй зүйл”³ гэдгийг тайлбарлан бичжээ. Тиймээс орхилтыг цогц санаа бүхий эхийн түвшинд тайлбарлах шаардлагатай юм. Өгүүлбэр, цогцолбор, эх болон тэдгээрийн орхилтоос гадна уг төгс санааны хүрээ дэх өгүүлэмж нь тухайн юм үзэгдлийн талаарх цогц мэдээллийг өгүүлнэ.

Монголын нууц товчоонд нэрийг тэг хэлбэрт оруулж, улмаар уг юмыг хэсгээр төлөөлүүлэх аргыг хэрэглэсэн жишээ мөн ажиглагдав. Юмны нэрийг орхисон, уг юмыг хэсгээр төлөөлүүлсэн гэдгийг эхийн хам бүтцийн хүрээнд илрүүлэх боломжтой юм. Жишээ нь:

§86: “qutu’ar üdür gü’ün ni’uba-je ke’eldüjü ö’er ja’ura nengjileldüya ke’eldüjü nengjileldüba sorqan-sira-yin ger-tür tergen-tür iseri-yin döro güртеle nengjijü qoyitu

³ Ш.Лувсанвандан “Хэлний өнгөн ба гүн бүтцийн тухай асуудалд” өгүүлэлдээ “Хэлний янз бүрийн дохионы дотроос үгэлбэр ганцаараа төгс дохио болдог, үгэлбэр заавал хоёр бүрэлдэхүүнтэй байдаг, тэр хоёр бүрэлдэхүүний нь түрүүчийнх нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржиж, сүүлчийнх нь үйл үгийн цаг заах, захирах хүсэх хэлбэртэй байдгийн учир юу юм бэ? гэсэн асуулт гарч ирнэ. Үгэлбэр нь бодот ертөнцийн юм үзэгдлийг хөдөлгөөний хамт заасан дохио учир харьцангуй утга төгссөн байна. Хөдөлгөөнгүй юм, юм хөдөлгөөн гэж байхгүй тул энэ хоёр бүрдвэл утга төгс болох нь мэдээж хэрэг болно. Нэгэнт үгэлбэр нь юм, хөдөлгөөн хоёрыг багтаасан дохио байдаг бол юмыг заасан нь нэрээр, хөдөлгөөнийг заасан нь үйл үгээр хэлбэржих нь зүйн хэрэг болно” (1978: 55-60), “Үгэлбэр, түүний бүрэлдэхүүн нь хэчнээн олон үгээр бүтсэн ч хос хосоороо нийлсээр нэг бүхэл цогц болно. Энэ учраас үгэлбэр нь нэг бүхэл цогц байвч хоёр бүрэлдэхүүн-үглэгдэхүүн, үглэхүүнтэй байна. Хоёр бүрэлдэхүүн нь хоёр хоёр дөрөв, тэр дөрөв нь хоёр хоёр найман бүрэлдэхүүнтэй байх мэт. Эдгээр бүрэлдэхүүн гишүүний өдүй төдүй нь далд байна. Тэр далд гишүүнд харьцаагаараа мэдэгдэнэ” (1978: 46-58) гэжээ.

nungqasutu tergen-tür unuju amasar-a бүкүй нунгqасу таталжу көл-түр гүркүй-түр sorqan-sira ene basa eyimü qala'un-a nungqasun dotora ker da'usqu kē'esü nengji'ülsün bawuju yorciba (Rachewiltz 1972: 33) [Гутгаар өдөр “Хүмүүн нуув зэ!” хэмээлдэж, “Өөр зуур нэгжлэлдье” хэмээлдэж нэгжлэлдэв. Сорхон Шарын гэрт, тэргэнд, исрийн доор хүртэл нэгжиж, хойд унгаст тэргэнд онож, амсараа бүхүй унгас таталж, [Тэмүжиний] хөлд хүрэхүйд Сорхон шар: “Энэ бас ийм халуунаа (халуунд) унгасан дотор хэр дуусах?” хэмээвээс нэгжүүл бууж зорчив. Чоймаа, 2022: 43]. Энэхүү жишээнээс үзвэл, хэний хөл, юуны хөл гэдэг зүйл тодорхойгүй бус байгаа тул эхийг бүхэлд нь юм уу, уг юм үзэгдлийн тухай өгүүлсэн хэсгийг гүйцээн уншиж байж нэрийн орхилт тодорхой болно. Дээрх төгс санааг урагшлуулан гүйцээж уншихад, *Тэмүжин* гэдэг хүний тухай өгүүлж байсан тул уг нэрийг орхиж, түүний биеийн хэсгээр нэрийг төлөөлүүлэн өгүүлсэн болохыг илрүүлнэ. Иймээс эхийг уншиж судлах, холбоосжилтын тогтолцоог тодруулахад цогц санааг жишээ болгон авч үзэхийг чухалчилдаг юм. Дээрх төгс санааны нэрийн орхилт, түүний тэг хэлбэр болон нөхөн харуулсан жишээг дараах байдлаар загварчилж болно. Үүнд:

1. §86: “qutu'ar üdür gü'ün ni'uba-je ke'eldüjü ö'er ja'ura nengjileldüya ke'eldüjü nengjileldüba sorqan-sira-yin ger-tür tergen-tür iseri-yin döro gürtele nengjiü qoyitu nungqasutu tergen-tür unuju amasar-a бүкүй нунгqасу таталжу Ø көл-түр гүркүй-түр sorqan-sira ene basa eyimü qala'un-a nungqasun dotora ker da'usqu kē'esü nengji'ülsün bawuju yorciba (Rachewiltz 1972: 58) [Гутгаар өдөр “Хүмүүн нуув зэ!” хэмээлдэж, “Өөр зуур нэгжлэлдье” хэмээлдэж нэгжлэлдэв. Сорхон Шарын гэрт, тэргэнд, исрийн доор хүртэл нэгжиж, хойд унгаст тэргэнд онож, амсараа бүхүй унгас таталж, Ø хөлд хүрэхүйд Сорхон шар: “Энэ бас ийм халуунаа (халуунд) унгасан дотор хэр дуусах?” хэмээвээс нэгжүүл бууж зорчив. Чоймаа, 2022: 43].

2. §86: “qutu'ar üdür gü'ün ni'uba-je ke'eldüjü ö'er ja'ura nengjileldüya ke'eldüjü nengjileldüba sorqan-sira-yin ger-tür tergen-tür iseri-yin döro gürtele nengjiü qoyitu nungqasutu tergen-tür unuju amasar-a бүкүй нунгqасу таталжу [temüjin-i] көл-түр гүркүй-түр sorqan-sira ene basa eyimü qala'un-a nungqasun dotora ker da'usqu kē'esü nengji'ülsün bawuju yorciba (Rachewiltz 1972: 58) [Гутгаар өдөр “Хүмүүн нуув зэ!” хэмээлдэж, “Өөр зуур нэгжлэлдье” хэмээлдэж нэгжлэлдэв. Сорхон Шарын гэрт, тэргэнд, исрийн доор хүртэл нэгжиж, хойд унгаст тэргэнд онож, амсараа бүхүй унгас таталж, [Тэмүжиний] хөлд хүрэхүйд Сорхон шар: “Энэ бас ийм халуунаа (халуунд) унгасан дотор хэр дуусах?” хэмээвээс нэгжүүл бууж зорчив. Чоймаа, 2022: 43].

Энэхүү эхэд Сорхон Шар Тэмүжинийг хамгаалж асарсан тухай давхарласан тайлбар бүхий цогц мэдээллийг өгүүлжээ. Нэрийн орхилт бүхий төгс нэгж нь өгүүлсэн санааг үргэлжлүүлэх утгыг илтгэх ба үйлдэгч, өгүүлэгчийн сэтгэл хөдлөл, харилцаа хандлага, баймж үнэлэмжийг харуулна. Тодруулбал, юм үзэгдлийн тухай нэгэнт тайлбарлаж, танилцуулсан бол мөнөөх санааны үйлдэгчийг зарим хэсэгт дахин өгүүлэлгүйгээр өөр үг, өгүүлбэрээр орлуулах нь өрнөлийг буй болгох зохиомжийн арга болно.

Орхилт бол мэдээллийн бүтэц өргөжин тэлэхэд чухал үүрэгтэй хэрэглүүр юм. Учир нь орхилт бүхий төгс нэгж юмны нөхцөл шалтгааныг өгүүлж, дүгнэлт, тайлбар, нэмэлт агуулж байгаа бол онцолбор мэдээлэл болно. Эхэд буй цогц санаа бүхий хэд хэдэн өгүүлбэр, харилцаа ярианы зарим төгс нэгжид нэрийг орхин найруулдаг. Нэрийг тухайн юмны тооны нэрээр төлүүлэх нь түгээмэл хэрэглэдэг арга ажээ. Жишээ нь:

§252: “cinggis-qahan jungdu-yin altan mönggün et a’urasun ya’u ke inu to’ola’ulurun önggür-bawurci arqai-qasar sigi-qutuqu qurban-I ilēba ede qurban-i ayisai ke’en qada esergü uqtun altatai hartai a’urasu bari’at jungdu dotoraca qarcu esergü ireba” (Rachewiltz 1972: 147-148) [Чингис хаан Жүндүгийн алтан мөнгөн, эд агуурс, юу хээг инү тоолуулруун (тоолуулахаар) Өнгүр буурч, Архай Хасар, Шихи Хутугу гурвыг илгээв. Эд гурвыг Ө айсуй хэмээн Хада эсрэг угтан, алтат артай эд агуурс бариад, Жүндү дотроос гарч, эсрэг ирэв. Чоймаа 2022: 215). Энэхүү эхэд буй “...Өнгүр буурч, Архай Хасар, Шихи Хутугу гурвыг илгээв” гэдэг төгс санааны нэрийг “Эд гурвыг Ө айсуй” гэсэн тооны нэрээр төлөөлүүлэн, төгс санаанд хураажээ. Нэр бүхий төгс нэгж нь дэвсвэр мэдээлэл агуулж байгаа бол нэрийн орхилт бүхий төгс нэгж нь онцолбор мэдээлэл болж байна. Тус нэрийн орхилт нь хураангуйлсан орхилт төдийгүй эхийн нарийвчилбар болно.

Дүгнэлт

Тогтолцоот үүргийн хэл шинжлэлийн онолын хүрээнд холбомжийг орхилт, орлуулал, төлөөлүүлэл, үгийн сангийн холбомж, холбоос гэж ангилан судалж буй жишгээр монгол хэлний нэрийн орхилтыг тайлбарлалаа. Монголын нууц товчоонд буй нэрийн орхилтын зарим жишгээрээс ажиглавал, эхний өгүүлсэн санаанд буй нэр (өгүүлэгдэхүүн, тусагдахуун)-ийг удаах өгүүлбэрт орхиж, тэг хэлбэрээр илрүүлэн өгүүлж байна.

Нэрийн орхилт юм үзэгдлийг үнэлж дүгнэх баймж утга илтгэх; эхийн санааг нарийвчлах, өргөжүүлэх, үргэлжлүүлэх арга болох ажээ.

Ном зүй

- Halliday, M.A.K., Hasan, Riquiia. 1976. *Cohesion in English*. London: Longman.
- Halliday, M.A.K., & Matthiessen, C. M. I. 2014. M. Halliday’s *Introduction to Functional Grammar (Fourth Edition)*. London and New York: Routledge.
- Thompson, G. 2014. *Introducing Functional Grammar (Third Edition)*. London and New York: Routledge. 225
- Rachewiltz, Igor de. 1972. *Index to the Secret History of the Mongols*. Bloomington: Indiana University Publications.
- Лувсанвандан, Ш. 1978. Хэлний өнгөн ба гүн бүтцийн тухай асуудалд. *Studia Mongolica*, V(13): 55-60;
- Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган, 7: 309-313.
- Чоймаа, Ш. 2017. Монголын нууц товчооны хэлийг судлах тухай асуудалд. *Монгол хэл, бичиг, соёл судлал, Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган*. 2: 7-15.
- Чоймаа, Ш. 2022. *Монголын нууц товчоон (Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг)*. Болор судар хэвлэлийн газар.

Abstract

Within the theoretical framework of Systematic Functional Grammar, cohesions are classified as ellipsis, substitution, reference, lexical cohesion, and conjunction. Accordingly, the author has analyzed and explained nominal ellipsis in Mongolian. Based on some nominal ellipsis observed in the Secret History of Mongolian, subjects and objects occurring in the first sentence are omitted in the next sentence but expressed as zero forms

The nominal ellipsis expresses the modal meaning to evaluate the phenomenon, and it will be a method to elaborate, extend and enhance the idea of texts.